

Мэдээллийн системийн менежментийг боловсронгуй болгох нь

Их засаг ОУИС-ийн мэдээллийн системийн менежментийг боловсронгуй болгох боломж, бодлого дэвшүүлэх нь

Пүрэвийн Бямбатөгс¹, Нямхайнямбуугийн Ган-Эрдэнэ²
ИЗОУИС-ийн Үндэсний инженер технологий сургууль
Мэдээллийн технологийн хөтөлбөрийн баг
byambatugs@gmail.com¹, ganerdeneub@gmail.com²

Хураангуй – Энэхүү судалгааны ажлаар бид Их Засаг олон улсын их сургуулийн менежментийн мэдээллийн системд шинжилгээ хийн шинэ бодлогын хэв загварыг дэвшүүлэхийг зорьж ажиллалаа. Дэлхий улам бүр даяаршиж байгаа өнөө үед манай сургууль гадаад дотоодын томоохон сургуулиудтай өрсөлдөхийн тулд сургалтын үйл ажиллагаа, процессдоо мэдлэгийн менежментийг хэрэгжүүлэн, удирдлага, үйл ажиллагаандаа мэдээллийн системийг зөв ашиглан, зөв шийдвэр гарган давуу талаа хөгжүүлэх нь нэн чухал болоод байна. Бид судалгаандаа оюунлаг, бүтээлч, мэдлэгийг үйлдвэрлэгч хамт олон, багийн мэдлэгийн менежментийн онол практикийн судалгаануудыг хийж энд үйлдвэрлэгдэж буй мэдлэг, мэдээллүүдийг мэдээллийн систем ашиглан хэрхэн үр дүнтэй удирдах тухай судлахыг зорилоо.

Түлхүүр үг – Интернет; Мэдлэгийн менежмент; Мэдээллийн систем; ERP

УДИРТГАЛ

Аливаа байгууллага амжилтанд хүрэх, өрсөлдөх чадвартай байхгоол үндэс нь тухайн байгууллагын бодит материаллаг нөөцөд тулгуурлаад зогсохгүй мөн үл үзэгдэх нөөц болох мэдлэгийн менежментийг хэрэгжүүлэх, түүнийг тусгайлан хөгжүүлэх явдал юм. Мэдлэгийн менежмент (knowledge management) гэдэг нь байгууллагын мэдлэгийг бүтээх, цуглуулах, хадгалах, хөгжүүлэхэд чиглэгдсэн үйл ажиллагаануудын цогц юм. Мэдээллийн технологийн салбар асар хурдацтай хөгжиж буй өнөө үед энэхүү салбарыг ашиглан мэдлэгийн менежментийг хэрэгжүүлэн, оновчтой шийдвэр гаргах нь байгууллагын ажлын бүтээмжид асар их нөлөөлнө гэж үзсэний үндсэн дээр энэхүү сэдвийг сонголоо. Тэр дундаа боловсролын байгууллагын бүтээгдэхүүн өөрөө мэдлэг байдаг. Тэнд төвлөрч, урган гарч байгаа мэдээллүүдийг хэрхэн өөрийн байгууллагад ашигтайгаар нөөцлөн хадгалах хөгжүүлэх нь манай ИЗОУИС-ийн хувьд нэн шаардлагатай тулгамдсан асуудал хэмээн үзэж байна. Мэдлэгийн менежментийн онол, хэрэглээ, мэдээллийн системийн онол, практикийн судалгааг хийж, олон улсын стандарт, чанарын шаардлагад нийцсэн мэдээллийн системийн менежментийн нэгдсэн бодлогын хэв загварыг боловсруулах тухай судалж байгаад судалгааны ажлын шинэлэг тал оршино гэж үзэж байна.

Судалгааны ажлын зорилго: Энэхүү судалгааны ажлын хүрээнд мэдлэгийн менежментийг судлан түүнийг зөв зүйтэй удирдахын тулд мэдээллийн систем, мэдээллийн технологийг түүний гол гүйцэтгэгч болгон байгууллагын ашигт ажиллагааг нэмэгдүүлэх тулгуур зарчим, бодлогын хэв загварыг дэвшүүлэх нь гол зорилго юм.

Судалгааны ажлын зорилтууд:

- Мэдлэгийн менежментийг судлах;
- Мэдээллийн системийн менежментийг судлах;
- Мэдээллийн системийн менежментийн олон улсын жишиг болон монгол улсад мөрдөгдөж буй стандартуудыг судлах;
- “Их Засаг” ОУИС-ийн мэдээллийн системийн менежментийн өнөөгийн байдлыг судлах
- “Их Засаг” ОУИС-ийн мэдээллийн системийн менежментийг боловсронгуй болгох бодлого дэвшүүлэх зэрэг болно.

1. МЭДЛЭГИЙН МЕНЕЖМЕНТ БОЛОН МЭДЭЭЛЛИЙН СИСТЕМ ИЙН МЕНЕЖМЕНТ

1.1. МЭДЛЭГИЙН МЕНЕЖМЕНТ

Манай байгууллагын хувьд мэдлэгийн менежментийн эцсийн зорилго нь хэрэгтэй мэдлэг, мэдээллийг зөв хүнд нь оновчтой цаг хугацаанд хүргэх системийг бүрдүүлэх, байгууллагын хувьд хуучирсан мэдлэгийг хурдан танин мэдэн оношилдог байх, түүнчлэн багш ажилчдыг шинэ мэдлэг бий болгож түүнийг байгууллагын зорилгод идэвхтэй ашиглаж өөрчлөгдөж байгаа орчинд дасан зохицох, орчиноо залж жолоодоход дэмжихэд чиглэнэ. Мэдлэгийн менежментийн үндсэн асуудлуудад шинэ мэдлэгийг бий болгох, гадаад эх үүсвэрээс үнэ бүхий мэдлэгийг олж авах, шийдвэр гаргахад шаардлагатай мэдлэгийг ашиглах, байгууллагын багш, ажилтануудын дунд мэдээлэл, мэдлэгийг түгээх, шинэ ажилтнуудад хүргэх, харилцан суралцах боломжийг бүрдүүлэх, шинэ зорилго зорилтыг шийдвэрлүүлэхэд багш ажилтнуудын мэдлэг чадварыг дайчлах, мэдлэгийг байнга сайжруулан орчны өөрчлөлттэй уялдуулах зэрэг ойлголтууд багтана.

1.2. МЭДЭЭЛЛИЙН СИСТЕМ ИЙН МЕНЕЖМЕНТИЙН БҮТЭЦ, БҮРЭЛДЭХҮҮН

Аливаа байгууллага үйл ажиллагааг удирдах үндэс нь менежмент байдаг. Байгууллага зорилго, зорилтуудаа тодорхойлж түүнд хүрэх үйл ажиллагаагаа төлөвлөх, төлөвлөгөөний дагуу үр ашигтайгаар зохион байгуулах, үүний тулд ажилчдаа манлайлж идэвхижүүлэх, хяналт тавих зэрэг цогц зүйлс орно.

Удирдлагын философийн үүднээс байгууллагын удирдлагын бүтэц, зохион байгуулалт нь үйл ажиллагаа, удирдлага, стратеги гэсэн түвшнүүдээр тодорхойлогдоно. Түвшин бүрт гүйцэтгэх үүргээрээ ялгаатай дэд системүүд хоорондоо харилцан нягт уялдаатай ажиллаж, менежерүүдийг цаг алдалгүй, үнэн зөв мэдээллээр хангах ёстой. Менежер хүн удирдлагын

үндсэн үйл ажиллагаануудаа хэрэгжүүлэх явцдаа байнга шийдвэр гаргах бөгөөд ингэхдээ мэдээллийн системийг ашигладаг.

1.3. БАЙГУУЛЛАГЫН НӨӨЦ ТӨЛӨВЛӨЛТИЙН СИСТЕМ БУЮУ ERP /ENTERPRISE RESOURCE PLANNING/ СИСТЕМ

Орчин үеийн байгууллагын нөөц төлөвлөлтийн систем буюу ERP /enterprise resource planning/ систем нь Байгууллагын талаарх нийт мэдээллийг харахын тулд байгууллагын энгийн мэдээллийн баазыг зөвхөн хэдэн хэлтсүүдийг ч бус, олон салбаруудыг нэгтгэх зорилгоор ашигладаг. Ингэснээр ERP систем нь байгууллагын санхүү, хүний нөөц, үйлдвэрлэл, маркетинг зэрэг бизнесийн үйл ажиллагааг нь илүү зохион байгуулалттай, ашигтай явуулах боломж олгоно.

Сүүлийн үед ERP-зах зээл дэх хамгийн том өөрчлөлт нь компаниудын шаардлагад илүү нийцэж, олон асуудлыг нэг дор шийдвэрлэх боломжтой болсон байна. Түүнчлэн програм хангамжийн компаниуд ERP шийдлийг хэрэглэхэд илүү хялбар, энгийн ажиллагаатай, элдэв янзын олон тохиргоо хийх явдлыг багасгасан байна.

Түүнээс гадна хэрэглэгчид зах зээлийн өөрчлөлтөнд илүү хурдан хариу үйлдэл үзүүлэх боломж олгохын тулд програм хангамжийн компаниуд системийг илүү хөдөлгөөнтэй, өөрөөр хэлбэл уян хатан болгох арга замыг хайж байна. Мөн ERP системийг ашигладаг ихэнх компаниуд тухайн шийдлээс илүү их бизнесийн үр өгөөж хүртэхийг хүсч байна.

Програм хангамжийн шийдэл нь байгууллагын хэрэгцээ шаардлагад нийцсэн, онцлогт нь тохирч ажиллах ёстой. Хэрэв үнэхээр зөв програм сонгож чадвал маш цөөхөн шинэчлэлт, сайжруулалт хийх хэрэгтэй. Ихэнх компаниуд ERP системийн онцлог шинжүүдийг судалж байж аль програмыг авах шийдвэрээ гаргадаг. Ихэнх ERP шийдлийн хувьд модулиуд нь адил байх боловч тэдгээр модулиудын онцлог, асуудал шийдвэрлэх байдал нь эрс тэс ялгаатай байдаг. Олон төрлийн шийдэл байх бөгөөд байгууллагууд яг аль шийдэл тухайн байгууллагын онцлог, үйл ажиллагаанд нь тохирохыг оновчтой сонгох хэрэгтэй. Зөв сонголт хийж чадвал уг шийдэл нь байгууллагын эрхэм зорилго, хэтийн төлөвт маш том хөрөнгө оруулалт болох болно.

Ихэнх байгууллагын хувьд ERP систем маш том боломжийг олгодог бөгөөд орлогоо нэмэгдүүлж, бүтээмжээ дээшлүүлж, ашигт ажиллагаагаа сайжруулж, зардлаа зөв зохион байгуулахад нь тусалдаг. ERP систем нь санхүү, үйлдвэрлэл, хүний нөөц, борлуулалт зэрэг хоорондоо ялгаатай олон системүүдийг нэгтгэнэ. Системийн боловсруулах төрөл бүрийн мэдээллийн тусламжтай хэрэглэгчид байгууллагынхаа зорилт, стратегитай холбоотой бүхий л шийдвэрийг илүү хялбар, оновчтой байдлаар гаргах боломжтой.

Өнөөдөр бараг бүх байгууллага, компаниуд ERP системийг ашиглаж байна. Ашиг орлого нь нэмэгдэх тусам уг системийн хэрэгцээ шаардлага улам бүр ихэсч, зарим байгууллагууд хуучирсан ERP системээ шинээр сольж, харин зарим нь цоо шинээр уг шийдлийг үйл ажиллагаандаа нэвтрүүлж байна.

ERP систем үйлдвэрлэгч томоохон компаниуд энэхүү хандлагыг мэдэрч ERP (ERP), харилцагчийн удирдлагын систем (CRM), нийлүүлэлтийн сүлжээний удирдлага (Supply chain management), худалдан авалт, шийдвэр гаргалт, байгууллагын портал сайт болон бизнесийн хэрэглээний бусад программуудыг нэгтгэсэн, вэбд хандах боломжтой цогц программ гаргаж эхэлсэн.

2. ИХ ЗАСАГ ОУИС-ИЙН МЭДЭЭЛЛИЙН СИСТЕМ ИЙН МЕНЕЖМЕНТЭД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ, МЭДЭЭЛЛИЙН СИСТЕМ ИЙН МЕНЕЖМЕНТИЙН ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА

ИЗОУИС-ийн мэдээлэл технологийн өнөөгийн төлөв байдал.

Сургалтын албаны систем нь xCloud, Санхүү бүртгэлийн систем нь “Даймонд”, номын сангийн програм нь Lib4U зэрэг дэд системүүдийг ашигладаг.

Сургалтын албаны систем нь Их засаг олон улсын их сургуулийн сургалтын процедурт нийцэхгүй програмыг ашиглаж байна. Тус систем нь оюутан, багш, сургалтын алба хоорондын харилцаа холбоог оюутны хичээл сонголтоор зохицуулагддаг систем юм.

Шинжилгээнээс хийх дүгнэлт: ИЗОУИС нь одоогийн байдлаар өөр өөр нэгж, хэлтсүүдэд зориулалтаараа ялгаатай 5-н программ хангамж ашиглаж байгаа нь тус байгууллагын мэдээллийн системийн хэрэглээ дутмаг байгааг харуулж байна. Зарим хэлтэст програм хангамж байхгүй байна. Тухайлал дараах системүүд шаардлагатай байна. Үүнд: Хүний нөөцийн систем, архивийн програм гэх мэт

ИЗОУИС-ийн Мэдээллийн технологийн алба нь 5 ажиллагчидтай төдийгүй тэдгээр нь байгууллагын дотоод сүлжээ болон интернэт сүлжээ, техник хангамжийн бүрэн бүтэн байдлыг голчлон хариуцаж байна. Энэ нь байгууллагын мэдээлэл технологийн бодлого тодорхойлж явах нөхцөл бололцоо гарахгүй байна.

ИЗОУИС-ийн мэдээллийн технологийн чиглэлийн алба, нэгжүүдэд зориулалтын глобал стандартын програм хангамжийг нэвтрүүлэн түүний тогтвортой найдвартай ажиллагааг хангаж ажилладаг байх нь ИЗОУИС бүрэн хүчин чадлаараа, үр ашигтай, өндөр бүтээмжтэй, хурдтай үйл ажиллагаа явуулахад дэмжлэг болно.

(ERP) байгууллагын нөөцийн төлөвлөлтийн системийг нэвтрүүлснээр

1. Мэдээллийн системийн менежментийн уялдаа холбоог боловсронгуй болгох
2. Нэгдсэн мэдээллийн сан үүсгэх, түүнд зөвхөн хандах эрх бүхий удирдгуудад дотоод сүлжээгээр нэвтрэх эрхийг нээж өгөх
3. Мэдээллийн сангийн нууцлал хамгаалалтыг өндөр түвшинд хийж өгөх

ИЗОУИС-ийн мэдээллийн системийн менежментийг шинжилж үзэхэд мэдээллийн технологийн шинжтэй нилээд олон сул талууд ажиглагдаж байна. Гэтэл энэхүү мэдээллийн технологийн сул талууд нь байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаанд нөлөөлж байдаг байна. Үүнд:

1. Нэгдсэн мэдээллийн сан байдаггүй учраас удирдлагад зориулсан тайлан гаргаж өгөхөд хүндрэлтэй, цаг их ордог, гар ажиллагаа ихтэй.
2. Нэгдсэн маркетингийн болон хүний нөөцийн систем байдаггүй.
3. Сургалтын албаны програм нь сургалтын процедуртай таарахгүй

2.1. ИХ ЗАСАГ ОУИС-ИЙН МЭДЭЭЛЛИЙН СИСТЕМ ИЙН МЕНЕЖМЕНТИЙГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ БОДЛОГО ДЭВШҮҮЛЭХ НЬ

Боловсролын байгууллагын гол үйл ажиллагаа мэдлэгийг бүтээх чанартай сайн боловсон хүчин нийгэмд бэлтгэх процесс болно. Аливаа байгууллага өрсөлдөх

чадвар сайтай байж, бизнесийн ашиг, үр өгөөж өндөр байх нь тухайн байгууллагын урт хугацааны стратеги төлөвлөлт, түүний хэрэгжилтээс хамаарна. Байгууллагын стратеги бол байгууллага урт хугацаанд өмнөө тавьсан зорилгодоо хүрэхийн тулд авч хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаануудын ерөнхий хэв загварууд юм. Тухайн бизнесийн байгууллага салбарын дундаж ашгийн түвшнээс дээгүүр ашигтай ажиллаж байж өрсөлдөх чадвартай байдаг. Өрсөлдөөнд ялах үндсэн нөхцөл нь гол өрсөлдөгчөөсөө илүү ашгийн түвшинтэй ажиллах явдал юм. Тэгэхээр стратеги төлөвлөлтөд мэдлэгийн менежментийг зайлшгүй тусгаж өгөх нь зүйтэй юм.



Зураг 2 Байгууллагын стратеги төлөвлөлт мэдээллийн системийн менежменттэй холбогдох нь


Эх үүсвэр: Судлаачийн төсөөлөл

Мэдлэгийн менежментэд тухайн байгууллагын мэдлэг мэдээллийг удирдах процесс бүхэлдээ хамаарагдана. Мэдлэгийн менежмент нь өөрөө нийт ажиллагчдын мэдлэгийг удирдах цогц үйл ажиллагаа юм. Их Засаг ОУИС-д мэдлэгийн менежментийг мэдээллийн системтэй уялдуулсан цогц систем буюу ERP системийг нэвтрүүлэх нь зүйтэй юм.

Их Засаг ОУИС-ийн Байгууллагын нөөц төлөвлөлтийн систем буюу ERP системийн үйл ажиллагаа, систем хоорондын үйл ажиллагааг зураглалал:

Их Засаг ОУИС-ийн Байгууллагын нөөц төлөвлөлтийн систем буюу ERP системтэй болсноор дараах давуу талуудтай.

- Нэгдсэн мэдээлэл
- Мэдээллийн үнэн бодит байдлыг өсгөх
- Үйл ажиллагааг автоматжуулах, гар ажиллагааг багасгах
- Дотоод хяналт
- Сургалтын процессын оновчтой зохион байгуулалт, үр ашиг
- Олон улсын санхүүгийн тайлангийн стандарт(IFRS)-ыг хангах
- Бизнесийн хурдыг нэмэгдүүлэх
- Зардлыг бууруулах
- Мэдээллийн системийн цогц байдал, системтэй техник үйлчилгээ
- Дэлхийн түвшний best practice хэрэгжүүлснээр давуу тал олох



Зураг-3: Их засаг олон улсын их сургуулийн мэдээллийн системийн менежментийн загвар

Эх үүсвэр: Судлаачийн төсөөлөл

2.2. Их Засаг ОУИС-ийн Мэдээлэл технологийн бодлогыг боловсронгуй болгох бодлогын бичиг баримт

2.2.1. Бодлогын үндэслэл

Их Засаг ОУИС /цаашид “Байгууллага” гэх/-д мэдээллийн системийн бодлого, журам боловсруулах үндэслэл:

- Байгууллагын компьютер, компьютерын сүлжээ, интернэтэд суурилсан мэдээллийн системийн хэрэглээ улам бүр өсөж байгаа бөгөөд үүнтэй уялдан учирч болзошгүй эрсдэл нэмэгдэж байна. Цаашид энэ чиглэлд баримтлах бодлого, чиг шугам шаардлагатай болж байна.
- Байгууллагын нэгж хэсгүүдийн өдөр тутмын үйл ажиллагаанд төрөл бүрийн програм хангамжууд ашиглагдаж, ихэнх баримт бичиг, мэдээлэл цахим хэлбэрт шилжсэнтэй холбоотойгоор тэдгээрийн хадгалалт, дамжуулалт, ашиглалт, уялдаа холбоо, зохион байгуулалт, хөгжүүлэлт, тасралтгүй ажиллагаа, аюулгүй байдалд баримтлах бодлого, зохицуулалтыг бий болгох хэрэгцээ үүсч байна.

2.2.2. Бодлогын хамрах хүрээ

- Байгууллагын удирдлага, салбар сургуулиуд, хөтөлбөрийн баг, нягтлан бодогчид, эд хариуцагчид, болон компьютерийн нөөцийг ашиглаж байгаа ажиллагсад болон оюутнуудболон гуравдагч талын бүх хүмүүст хамаарна.
- Байгууллагын компьютерийн нөөц, сүлжээ болон мэдээллийн системд ашиглагдаж буй төрөл бүрийн тоног төхөөрөмжүүд, програм хангамжууд хамаарна.

2.2.3 Бодлогын баримтлах зарчим, зорилтууд

Байгууллагын Мэдээллийн системийн бодлого гэдэг нь хийх үйлдлийн чиглэл өгсөн удирдлагын зааварчилгаа, чиглүүлэх зарчим, зүй зохистой дэд журам бөгөөд мэдээллийн системийн бодлогууд нь ажилтнуудад өнөө болон ирээдүйд шийдвэр гаргах зааварчилгаа болдог дээд түвшиний бичиг баримт юм.

2.2.4. Мэдээллийн системийн бодлоготой байх хэрэгцээ шаардлага

Байгууллагын мэдээллийн системийн бодлого, цогц журмыг боловсруулах хэрэгцээ, шалтгааныг дараахь байдлаар тодорхойлж байна. Үүнд:

- Хууль эрхзүй, дүрэм журамд нийцэх – Албан ёсны бодлого журамтай байх нэг чухал шаардлага нь энэ юм. Санхүүжилт хийх, санхүүгийн удирдлагын үйл ажиллагаанд тус болох, төр засаг, хууль, эрхзүй, эрүүл мэндийн зэрэг байгууллагууд нийтлэг жишгийг баримтладаг бөгөөд хууль, журамд нийцтэй байхын тулд тэдгээрийн ихэнх нь тогтмол үнэлгээ, шалгалтад орж байх хэрэгтэй байдаг.
- Шударга байх – Бодлого тогтоож өгсөнөөр тоглоомын талбар нэг болж, бүх оролцогчид ижил тэгш хандах боломжтой болдог.
- Уялдаа, холбоотой байх – Ижил төстэй асуудлыг төстэй арга барилаар шийдэх боломжтой болдог.
- Нэгдмэл ойлголттой байх – Бодлого тогтоож өгсөнөөр оролцогч талууд бүгд хүсч хүлээж буй зүйлийг тодорхой ойлгодог.
- Цаг хэмнэх – Дүрэм журмуудыг урьдаас тогтоож өгсөнөөр нөхцөл байдалд хэрхэн хандахаа тооцоолох цаг багасдаг. Зарим тохиолдолд бодлогууд нь асуудлаас урьдчилан сэргийлдэг.

• Байгууллагыг ажил хэрэгч болгох – Мэдээллийн системийн бодлоготой, түүнийгээ ашигладаг байх нь байгууллагыг ажил хэрэгч болгодог.

2.2.5. Байгууллагын мэдээллийн системийн бодлогын үндсэн зорилго

Байгууллагын мэдээллийн системийн бодлого нь дараах үндсэн зорилгуудтай:

• Мэдээллийн системийн зохион байгуулалт, цаашдын хөгжүүлэлтэнд баримтлах чиг баримжааг тодорхойлох

1. Байгууллагын мэдээллийн системийн бодлогыг тодорхойлж явуулах дүрэм журам дараалал, мэдээллийн ангилалын боловсруулалт, мэдээллийн объектуудын үнэлгээ, үйлдвэрлэлийн технологийн хүрээнд ашиглагддаг мэдээллийн урсгал болон өгөгдлийн бүтцийн технологийн, Байгууллагын багш, ажилтны гүйцэтгэж байгаа ажилд дүн шинжилгээ хийх.

2. Байгууллагын үндсэн сургалтын -процессийн мэдээллийн загварчлалыг гаргаж цаг тухайд нь шинэчлэн өөрчлөх.

- Байгууллагын ажлын байруудыг мэдээллээр хангах
- Байгууллагын мэдээллийн системд мэдээллийг оруулах, боловсруулах, хадгалах болон харуулах үйл явцын дэс дараалал
- Гадаад орчинд чиглэгдсэн мэдээллийн урсгал
- Мэдээлэл ашиглах болон мэдээллийн аюулгүй байдлын эрх үүргийн систем,
- Байгууллагын мэдээллийн технологийн дэд бүтэц.

5. Мэдээллийн технологийн бодлогын гүйцэтгэлд хяналтын ажлыг зохион байгуулах болон гарсан зөрчлүүдийг арилгах.

6. Байгууллагын үйл ажиллагааны-процессийн шаардлагын дагуу Мэдээллийн технологийн дэд бүтцэд өөрчлөлт оруулах, автоматжуулалтай холбоотой гэрээ контракт, худалдааны саналуудад дүн шинжилгээ хийж санал оруулах, нийлүүлэгч болон гүйцэтгэгчийг сонгох, гэрээ бэлтгэх, болон техникийн даалгавар, төслийн шийдвэр, төлөвлөгөө боловсруулах, техникийн болон ажилын гүйцэтгэл, хүлээн авах зэрэгт хяналтыг зохион байгуулах.

2.2.7. Мэдээллийн системийн бодлогын нийтлэг шинжүүд

Мэдээллийн технологийн бодлого нь үр нөлөөтэй байхын тулд тодорхой шалгууруудыг хангасан байх ёстой. Үүнд:

- Уян хатан байх – Үр нөлөөтэй бодлого нь байгууллагын тухайн үеийн төдийгүй ирээдүйн хэрэгцээ шаардлагыг хангасан, технологийн өөрчлөлтийг тусгасан байх ёстой.
- Үйл ажиллагааны онцлогт нийцсэн байх – Бодлого нь байгууллагын үйл ажиллагааны зорилгуудыг тусгасан байх ёстой.
- Хэрэглэхэд хялбар байх – Бодлого нь байгууллагын орчны бодит байдлыг тусгасан байх ёстой.
- Хэрэгжүүлэх боломжтой байх – Бодлого нь хэрэгжүүлэх боломжтой байх ёстой. Зорилгууд нь хүрч болохуйц, хэмжиж болохуйц байх ёстой.
- Цаг үеэсээ хамаарсан байх – Бодлого нь байгууллагын гадаад болон дотоод хүчин зүйлийн өөрчлөлтийг тусгасан байх ёстой.
- Зардлын хэмнэлттэй байх – Бодлого нь зардлын хувьд хэмнэлттэй байх ёстой. Бодлогыг хэрэгжүүлэхэд гарч буй материал, хүч хөдөлмөр нь зохицуулж буй хөрөнгийн үнэ цэнэтэй шууд хамааралтай байх ёстой.

• Байгууллагын мэдээллийн системийн бүрэн бүтэн, аюулгүй байдал, тасралтгүй ажиллагааг хангах

• Байгууллагын мэдээллийн системд учирч болзошгүй аюул эрсдлээс зайлсхийх, мэдээллийн системд учирсан аливаа аюулын үед авах арга хэмжээг тодорхой болгох

• Мэдээллийн системийн бүрэлдэхүүн хэсгүүдийн өдөр тутмын үйл ажиллагаанд баримтлах журмыг тодорхойлох

2.2.6. Мэдээллийн системийн бодлогын үйл ажиллагааны хүрээнд тавих зорилго:

3. Багш ажилтны ажлын бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор мэдээлэл технологийн нөөцийг бий болгох, хөтлөх, ашиглах, байгууллагын үйл ажиллагааны чиглэлүүдээр мэдээллийн удирдлагын системүүдийг бий болгох.

4. Үйл ажиллагааны процессд зайлшгүй чухал өөрчлөх шинчлэлүүдийг оруулах шаардлагуудыг боловсруулах, зорилго-зорилт-нөөц гэсэн зарчмаар загварчлагдсан төлөвлөгөөт ажлуудыг тодорхойлж дараах чиглэлээр гүйцэтгэлийг нь хангах:

- Албадсан шинжтэй байх – Бодлого нь албадсан өнгө аястай байх ёстой. Бодлого нь хэрэгжүүлэх аргуудыг нэгд нэггүй заадаггүй ч хэрэгжүүлэх боломжтой байдаг.
- Нийцтэй байх – Мэдээллийн системийн бодлого нь байгууллагад буй бусад төрлийн бодлого, дүрэм журмуудтай нийцтэй, нэгдмэл байх ёстой.

2.2.8. Мэдээллийн системийн бодлого, цогц журмын төрлүүд

Байгууллагын мэдээллийн системийн бодлого нь дараах хэсгүүдээс бүрдэнэ. Үүнд:

- Мэдээллийн системийн бодлого
 - Худалдан авалт, Хөгжүүлэлт, өөрчлөлтийн менежментийн журам
 - Мэдээллийн технологийн хөрөнгийн хяналтын менежментийн журам
 - Сүлжээ, дэд бүтцийн менежментийн журам
 - Бизнесийн програм хангамжийн менежмент
 - Ашиглалт, администраторын менежментийн журам
 - Нууцлалт, Аюулгүй байдлын менежментийн журам
 - Тогтвортой ажиллагааны менежментийн журам
 - Сервис, техник үйлчилгээний менежментийн журам
- Байгууллагын Мэдээллийн системийн бодлого нь энэхүү баримт бичгээр, түүнчлэн Мэдээллийн системийн бодлогын үндсэн дээр боловсруулагдсан цогц журам, Байгууллагын бусад норматив, дүрэм журмуудаар тодорхойлогддог.

1. Мэдээллийн системийн бодлого

- Байгууллагын мэдээллийн системийн бодлого нь дараах үндсэн зорилгуудтай:
- Мэдээллийн системийн зохион байгуулалт, цаашдын хөгжүүлэлтэнд баримтлах чиг баримжааг тодорхойлох
- Байгууллагын мэдээллийн системийн бүрэн бүтэн, аюулгүй байдал, тасралтгүй ажиллагааг хангах
- Байгууллагын мэдээллийн системд учирч болзошгүй аюул эрсдлээс зайлсхийх, мэдээллийн системд учирсан аливаа аюулын үед авах арга хэмжээг тодорхой болгох
- Мэдээллийн системийн бүрэлдэхүүн хэсгүүдийн өдөр тутмын үйл ажиллагаанд баримтлах журмыг тодорхойлох

ДҮГНЭЛТ

Судалгааны ажлын зорилго зорилтын хүрээнд мэдлэгийн менежментийг онол арга зүйн үүднээс судлан түүнийг мэдээллийн системтэй уялдуулан, хоорондын холбоо хамаарлыг гаргаж ирэн, түүний дагуу байгууллагын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, ашигт ажиллагааг сайжруулахын тулд мэдээллийн системийн бодлогын бичиг баримтыг боловсруулах явцад дараах ерөнхий дүгнэлтүүдийг хийж байна.

- Мэдлэг, мэдээлэл нь манай байгууллагад асар хэрэгцээтэй үл үзэгдэх нөөц юм. Энэхүү чухал нөөцийг зөв менежмент хийж олж авч, баримтжуулж, хадгалж, түгээж түүнийг байгууллагын үйл ажиллагааны бүх процессод зөв хэрэглэн стратеги, зорилго, зорилтуудад нийцүүлж, удирдлагын шийдвэр гаргалтанд дэмжлэг үзүүлэхүйцээр ашиглах нь нэн чухал юм. Манай байгууллага мэдлэгийн менежмент огт хэрэгжүүлдэггүй гэвэл өрөөсгөл ойлголт болно. Мэдлэгийн менежмент нь тодорхой хэмжээнд байгууллагад оршин байдаг ба түүнийг бодлогын түвшинд авч үзэн хэрэгжүүлэх нь нэн чухал юм.

- Мэдлэгийн менежментийг зөв хэрэгжүүлэхийн тулд мэдээллийн системийг ашиглах ёстой. Мэдээллийн системийн менежментийг боловсронгуй болгох асуудлыг системийн хандлагаар судалснаар түүний олон холбоос, мөн чанарыг тогтоох боломжтой. Байгууллагыг ийнхүү судлахдаа түүний зорилго, нэгж хэсгүүд, тэдгээрийн харилцан хамаарал, үйлчлэл, гадаад дотоод хүчин зүйлс, найдвартай ажиллагаа, хамгаалалт гэсэн үндсэн ойлголтуудад тулгуурлах ёстой гэж үзэж байна.

- Байгууллагын мэдээллийн системийн менежментийг боловсронгуй болгох асуудал нь удирдлагын бүтэц, зохион байгуулалттай нарийн уялдаатай явагдах ёстой. Мэдээллийн системийн менежментийг боловсронгуй болгох үйл ажиллагаанд менежер, системийн шинжээч, мэдээлэл технологийн ажилтнуудыг татан оролцуулах нь зүйтэй.

Их Засаг ОУИС-ийн мэдээллийн системийн менежментийн сул болон давуу талыг илрүүлэх, стратегийн хэрэгжилтийн уялдааг судлах ажлын хүрээнд дараах дүгнэлтүүдийг хийж байна.

✓ Мэдлэгийн менежментийн талаархи онол практикийн судалгааг хийж мэдээллийн системийн менежментийн хоорондын уялдаа холбоог гаргаж, олон улсын жишиг стандартын нийцүүлэн, Их Засаг ОУИС-ийн жишээн дээр хийхийг зорьж ажилласан ба мэдлэг, мэдээллийг чухал нөөц гэж үзэх, түүнийг байгууллагынхаа стратеги, зорилго, зорилтуудад нийцүүлж, мэдээллийн системийг энэ талаас нь судлах нь зүйтэй гэж үзэж байна.

✓ Мэдээллийн системийн менежментийн хэрэглээний цогц журмыг боловсруулан мөрдөж эхлэх нь байгууллагын тогтвортой үйл ажиллагаанд томоохон ач холбогдолтой бөгөөд цаашид журам тус бүрээр эсвэл үйл ажиллагааны төрөл хэсгээр нь Мэдээллийн технологийн мэргэжилтнээс зөвлөгөө авах, хамтран ажиллах хэлбэрээр сайжруулах, шаардлага стандартыг илүү нарийвчлан тодорхойлох нь зүйтэй.

✓ Их Засаг ОУИС-ийн стратеги болон менежментийн мэдээллийн систем, мэдээллийн технологийн стратегийн уялдаа холбоог илүү тодорхой болгох, олон улсын мэдээллийн технологийн засаглалын (IT Governance) стандарт, шилдэг арга барилын шаардлагуудыг тусгах, энэ чиглэлээр бодлогын цогц баримт бичиг боловсруулах шаардлагатай бөгөөд хойшид

стратегийн бодлогын түвшинд хэрэгжүүлэх нь зүйтэйг дэвшүүлж байна.

✓ ИЗОУИС нь одоогийн байдлаар өөр өөр нэгж, хэлтсүүдэд зориулалтаараа ялгаатай 5-н программ хангамж ашиглаж байгаа нь тус байгууллагын мэдээллийн системийн хэрэглэглээ дутмаг байгааг харуулж байна. Зарим хэлтэст програм хангамж байхгүй байна. Тухайлал дараах системүүд шаардлагатай байна. Үүнд: Хүний нөөцийн систем, архивийн програм гэх мэт

✓ ИЗОУИС-ийн Мэдээллийн технологийн алба нь 5 ажиллагчидтай төдийгүй тэдгээр нь байгууллагын дотоод сүлжээ болон интернэт сүлжээ, техник хангамжийн бүрэн бүтэн байдлыг голчлон хайриуцаж байна. Энэ нь байгууллагын мэдээлэл технологийн бодлого тодорхойлж явах нөхцөл бололцоо гарахгүй байна. Байгууллагын мэдээллийн системийн нэгдмэл байдал, өгөгдөл, мэдээллийн нэгдмэл байдлыг алдагдуулж, үйл ажиллагааны гүйцэтгэлд сөргөөр нөлөөлж байх эрсдэлтэй тул цаашид бүх үйл ажиллагааг цогцоор нь хөтлөх зориулалттай байгууллагын нөөцийн төлөвлөлтийн нэгдсэн систем(ERP)-ийг нэвтрүүлэх нь зүйтэй гэж үзэж байна.

Их Засаг ОУИС-ийн мэдээллийн технологийн чиглэлийн алба зориулалтын глобал стандартын програм хангамжийг нэвтрүүлэн түүний тогтвортой найдвартай ажиллагааг хангаж ажилладаг байх нь Их Засаг ОУИС үр ашигтай, өндөр бүтээмжтэй, хурдтай үйл ажиллагаа явуулахад дэмжлэг болно гэж үзэж байна.

IV. Ашигласан материал

Монгол хэл дээрх ном материалууд:

1. МУИС-Эдийн Засгийн Сургууль, Менежментийн тэнхим, 2013, *Менежмент*, ВСИ Хэвлэлийн компани, Улаанбаатар
2. Уянга. С, 2009, *Системийн шинжилгээ ба зохиомж*, Улаанбаатар принт ХХК, Улаанбаатар
3. Батбаяр. Р, 1985, *Бүртгэл тайлангийн системийг боловсронгуй болгох арга зам*, Улаанбаатар
4. Дорж. Т, 1987, *Үйлдвэрлэлийн удирдлагын процесс: Шийдвэр гаргах аргазүйн асуудал*, Улаанбаатар
5. Дорж. Т, Чимэд. Ү, 2000, *Менежмент*, Улаанбаатар,
6. Нарандэлгэр. Д, 2000, *Удирдлагын ерөнхий онол, математик загварчлал*, Улаанбаатар
7. Чимгээ. Д, 1998, *Менежментийн мэдээллийн систем*, Улаанбаатар
8. Их Засаг ОУИС, *Мэдээллийн технологийн бодлого*, 2012, Эрдэнэт
9. Ашигт малтмалын газар, *Мэдээллийн технологийн талаар баримтлах бодлого*, 2010, Улаанбаатар

Англи хэл дээрх материалууд:

1. Davenport, Thomas H., and Lawrence Prusak., 1999, *Working Knowledge: How Organizations Manage What They Know*. Boston, MA: Harvard Business School Press.
2. Kenneth C. Laudon, Jane P. Laudon, 2012, *Management Information Systems: Managing Knowledge*, 12th edition
3. Shannon, C.E., 1948, *A Mathematical Theory of Communication*, Bell System Technical Journal
4. James O'Brien, George M. Marakas, 2006, *Management Information Systems*
5. Robert D. Galliers, Dorothy E. Leidner, 2003, *Strategic Information Management*

O'Brien, James A, 1996, *Management Information Systems: Managing Information Technology in the Networked Enterprise*